МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.04.23 № 09/01 УАГ-САБ/2013/20-СТА-ТЕЗ

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Б.БАЛГАНСҮРЭН ТАНАА**

## ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Ерөнхий сайдын төсвийн багцын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

БНҮҮС, ХХЗХ нь сангийн бүрдүүлэлтийн талаар харилцан уялдаатай үйл ажиллагаа явуулалгүй ирснээс тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн 5 хувь нь БНҮҮС-д тайлангаа ирүүлэн орлогоо төвлөрүүлсэн байна.

Аудитын явцад сангийн бүрдүүлэлтийг шалгахад БНҮҮС-д "Мобинет" ХХК-иас 2012 оны 2 ба 5 дугаар сард нийт 46,5 сая төгрөг шилжүүлсэн нь данс андуурч ХХЗХ-д орсонг 2013 оны 4 дүгээр сард залруулсан нь өөр бусад БНҮҮС-д орох ёстой орлого ХХЗХ-д орсон байх магадлалтай байгаа бөгөөд эдгээрийг ХХЗХ ажлын 3 хоногт багтаан залруулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2–д "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх; " гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих" гэж заасныг үндэслэн дээр дурьдсан зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг 2013 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус хорооны ХХЗХ-ны дарга Б.Балгансүрэн, Ерөнхий нягтлан бодогч Д.Насанжаргал нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:**

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН АХЛАХ АУДИТОР** Л.ОДГЭРЭЛ

УХА0122

070181